

Цорж Дагбажанцаны зохист аялгууны шүлгүүд

Дамбийхорлоогийн НАРАНЦЭЦЭГ*
Монгол Улс, Улаанбаатар,
Шинжлэх ухааны академийн
Хэл зохиолын хүрээлэнгийн
Төвөд судлалын салбар

Received: Aug 08, 2025 | **Revised:** Dec 04, 2025 | **Accepted:** Dec 20, 2025

Хураангуй: Монголчуудын төвөд хэлт утга зохиолын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан зохиолчдын нэг нь Халхын Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошууны лам, Шар цорж хэмээн олноо алдаршсан Дагбажанцан (1855-1927) юм.

Номч мэргэн хамба С.Гомбожав 1959 онд “Монголчуудын төвөдөөр бичсэн зохиолын зүйл” өгүүлэлдээ “Дагбажанцан. Говь мэргэн вангийн хошууны Шар цорж хэмээн алдаршсан. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, зан үйл, залбирал, мөргөл зэрэг, бичмэл” (Гомбожав, 1959:22) хэмээн тэмдэглэсэн байдаг.

Энэ ламтны бие даасан намтар гараагүй бололтой. Өнөө хэр нь бичиж туурвисан ном зохиолынх нь талаар тусгайлан бичсэн судалгааны өгүүлэл үгүй. Шар цорж Дагбажанцан Монголын найман богдын тус тусын намтар, солдэв болоод Тавдугаар богдын лүндэнг төвөд хэлээр, Шударга дөлгөөн хааны зохиосон шүлэг маани зэрэг маани хөгжсөөх номыг монгол хэлээр, төвөд үсгээр бичсэн, нийт 20 орчим зохиолтой.

Шар цорж Дагбажанцаны 1912 онд төвөд хэлээр шүлэглэн бичсэн “Тийн удирдагч Жэвзүндамба их эрдэнийн намтар магтаал хувь сайтын сүсгийг сэргээгч оршвой” хэмээх Өндөр гэгээний намтар зохиол нь гарчгаасаа эхлээд бүхэлдээ төвөд шүлгийн үеийн тоо тэнцүү байх зарчмыг хатуу баримталж 9 үетэй бичсэн бөгөөд зохиолын бүлэг бүрд зохист аялгууны онолын дуу, дүрстийн чимгийн аргаар бичсэн шүлэг бий.

Түлхүүр үг: Шар цорж, Дагбажанцан, монголчуудын төвөд хэлт уран зохиол, намтар зохиол, зохист аялгуу, Өндөр гэгээний намтар

A poetic works of Tsorj Dagvajantsan

NARANTSETSEG Dambiikhorloo
The Sector of the Tibetan Studies,
Institute of Language and Literature,

* © Д.Наранцэцэг 2025
Email: narantsetseg_d@mas.ac.mn

Abstract: *One of the writers who made a significant contribution to the development of Tibetan literature written by Mongolian is Dagbajantsan (1855-1927), a lama of Bayan-Ovoo monastery in the Gobi Mergen Wang of the Tusheet Khan aimag of Khalkh, who is widely known as "Shar Tsorj". In his article "Tibetan Writings written by Mongolians" the khamba lama S.Gombojav wrote about him in 1959 as "Dagvajantsan. Known as "Shar Tsorj" in the Gobi Mergen Wang district. A man of the 20th century. His writings are in one volume, including rituals, prayers, and dedications"*

It seems that there is no independent biography of Shar Tsorj. Although we have not yet seen the ritual literature mentioned in the article by khamba lama Gombajav, it is clear that he wrote about 20 works, including the 9 biographies of the eight Mongolian Bogd Javzandamba khutugtu written in Tibetan, and the prayers and the poem named as "The Mani written by Shudarga Dulguun Khan" written in Mongolian. If we examine at the works that we have found in general, he wrote all his works in verse, with a total of 9 words per line, and wrote the titles of his works in lines or half-verses. He was a highly educated writer in Tibetan language. He obtained the practical the theoretical knowledge of Eastern theoretical composition theory. He wrote most of his works in the last years of his life.

Key words: *Shar Tsorj, Dagbajantsan, Tibetan literature written by Mongolian, autobiographical literature, Peotry, Biography of the first Jevzundamba Khutaght*

1. Удиртгал

Монгол зохиолчдын төвөдөөр бичсэн зохиолыг судлах, тэр дундаа тухайн зохиолын уран сайхны онцлогийг шинжлэхэд Зохист аялгууны онолын зарчмыг өөрийн зохиолдоо хэрхэн тусгасан байдлыг зайлшгүй авч үзэх ёстой. Энэ нь өнөөгийн монгол яруу найргийн уламжлал холбоо, бүтээлч шинэчлэлийг тодруулах, бүр нарийсган авч үзвэл уран сайхны дүр бүтээх арга хэрэгслийн түүхэн хувьсал хөгжил, түүний нийгэм, гоо зүйн үүрэг зорилго, уран сайхны эрэл нээлтийг шүүн үзэх судалгааны зорилго чиглэлтэй бүрэн нийцсэн, монголын уран зохиол судлалын чухал зангилаа асуудлын нэг болно. (Хүрэлбаатар, 1999:33).

Зохист аялгуу (санс: kāvyā, тө: snyan ngag) гэдэг нь буддын мэдлэг ухааны арван орны бага таван ухааны орны нэг, аливаа зохиол бүтээлийг утга, уянга, урлал төгс хэрхэн яаж бүтээх тухай онол туурвилын мэдлэг, уран яруугаар илэрхийлэх туурвил зүйн ухаан юм. Энэтхэгийн алдарт утга зохиолын онолч Дандины “Зохист аялгууны толь” (са: kāvyādarśa, тө: snyan ngag me long) бол шүлэглэсэн хэлбэрээр бичсэн уран зохиолын онол, найруулга зүй, уран яруу дүрсэлж, найруулж бичиж туурвихын эрдэм онолын ном бөгөөд дорно дахин хийгээд дэлхий нийтийн ард түмний уран зохиолын онолын сэтгэлгээнд томоохон байр эзэлдэг онолын голлох сурвалж болно.

“Зохист аялгууны толь” нь Энэтхэг, Төвөд, Монгол, Хятад, Балба зэрэг дорно дахины олон улс орны соёлын хүрээнд өргөн уламжлагдан тархаж, эдгээр улс орны яруу найргийн онолын сэтгэлгээнд хүчтэй нөлөө үзүүлсэн байдаг (Сумъяа, 2017:16).

VII зууны үед Дандины туурвисан “Зохист аялгууны толь”-ийг XIII зууны үед Төвөдийн их хэлмэрч Шонтон Доржжанцан, Энэтхэгийн зохист аялгууч Лакшмикара нар төвөд хэлээр, XVIII зуунд халхын хэлмэрч гүүш Гэлэгжанцан төвөдөөс монгол

хэлэнд орчуулжээ. Гэлэгжанцаны орчуулга хэдийгээр төвөд эхийг хатуу барьж, үгчлэн орчуулсан гэгддэг ч Дандины “Зохист аялгууны толь”-ийг дараа үедээ уламжлан хүргэсэн чухал ач холбогдолтой. Монголчууд зохист аялгууны шастирыг эх монгол хэлээрээ орчуулж, Монгол Данжуурын 205-р ботид хэвлүүлснээс (Цэрэнсодном, 1987:318) нааш түүнийг сурч судлан, утгын ба үгийн тайлбар бичих, жишээ шүлэг зохиох, даган дуурайх зэргээр монгол яруу найргийн онолын сэтгэлгээг хөгжүүлж ирсэн нь хойч үеийн зохиолчдын бүтээлд нөлөөтэй байв.

Тухайлбал, төвөд хэлээр ном зохиол туурвисан монгол эрдэмтэн лам нарын нэг болох Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошууны Шар цорж гэж алдаршсан Дагбажанцан ламтан төвөд, монгол хэлээр шүлэглэн бичсэн олон намтар, солдэв туурвижээ. Түүний зохиол нь:

- Анхдугаар богд Лувсандамбижанцаны намтар,³⁰ гар бичмэл, 118 хуудас
- Анхдугаар богд Өндөр гэгээн Занабазарын намтар солдэв,³¹ гар бичмэл, 9 хуудас
- Хоёрдугаар богд Жэвзүндамба хутагт Лувсандамбидонмэгийн намтар, гар бичмэл, судрын 7 хуудас
- Гуравдугаар богд Жэвзүндамба хутагт Ишдамбинямын намтар,³² гар бичмэл, судрын 7 хуудас
- Дөрөвдүгээр богд Лувсантүвдэнванчүгжигмэджамцын намтар,³³ гар бичмэл, судрын 21 хуудас
- Тавдугаар богд Жэвзүндамба хутагт Лувсанцүлтимжигмэдамбижанцаны намтар,³⁴ гар бичмэл, судрын 25 хуудас
- Зургаадугаар богд Жэвзүндамба хутагт Лувсанбалдандамбижанцаны намтар,³⁵ гар бичмэл, судрын 3 хуудас
- Долдугаар богд Жэвзүндамба хутагт Агванчойживанчүгпринлайжамцын намтар,³⁶ гар бичмэл, судрын 3 хуудас
- Наймдугаар богд Жэвзүндамба хутагт Агванлуванчойжинимаданзинванчүгийн залбирал,³⁷ гар бичмэл, судрын 3 хуудас

³⁰ རྣམ་འདྲེན་རྗེ་བཙུན་དམ་པ་རིན་པོ་ཆེའི།
|རྣམ་ཐར་བསྟོད་ཚིག་སྐུལ་བཟང་དང་གསོལ་བཞུགས།

³¹ རྣམ་འདྲེན་རྗེ་བཙུན་དམ་པ་རིན་པོ་ཆེའི།
|རྣམ་ཐར་གསོལ་འདེབས་སྐུལ་ལྷན་དང་གསོལ་བཞུགས། |

³² རྣམ་འདྲེན་རྗེ་བཙུན་དམ་པའི་རྣམ་ཐར་ལས།
|རྣམ་འདྲེན་སྐུ་ཕྱིང་གསུམ་པའི་རྣམ་ཐར་བཞུགས།

³³ རྣམ་འདྲེན་རྗེ་བཙུན་དམ་པའི་རྣམ་ཐར་ལས།
|རྣམ་འདྲེན་སྐུ་ཕྱིང་གསུམ་པའི་རྣམ་ཐར་བཞུགས།

³⁴ རྣམ་འདྲེན་རྗེ་བཙུན་དམ་པའི་རྣམ་ཐར་ལས།
|རྣམ་འདྲེན་སྐུ་ཕྱིང་ལྷན་པའི་རྣམ་ཐར་བཞུགས།

³⁵ རྣམ་འདྲེན་རྗེ་བཙུན་དམ་པའི་རྣམ་ཐར་ལས།
|རྣམ་འདྲེན་སྐུ་ཕྱིང་དྲུག་པའི་རྣམ་ཐར་བཞུགས།

³⁶ རྣམ་འདྲེན་རྗེ་བཙུན་དམ་པའི་རྣམ་ཐར་ལས།
|རྣམ་འདྲེན་སྐུ་ཕྱིང་བདུན་པའི་རྣམ་ཐར་བཞུགས།

³⁷ སྐུ་བས་གནས་མཐར་ཐུག་སྐུ་བས་མགོན་བརྒྱད་པ་ལ།

- Тавдугаар богдын ирээдүйг эш үзүүлсэн лүндэн "Эндүүрэл үгүй эш үзүүлсэн их тавдугаар богдын ирээдүйн эш үзүүлсэн машинд гайхамшигт оршвой",³⁸ гар бичмэл, судрын 3 хуудас

- "Шударга дөлгөөн хааны зохисон шүлэг маани оршвой"³⁹, богино барын судрын 2 хуудас.

Үүнээс гадна Шар цоржийг төвөд үсгээр, монгол хэлээр бичсэн маанийн хоёр, гурван ном бичсэн гэдэг аман мэдээ бий⁴⁰.

2. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

Шар цорж Дагбажанцан нь Монголын найман богдын намтар тэргүүтэй арав орчим намтрыг шүлэглэн бичжээ. Үүнээс бид “Тийн удирдагч Жэвзүндамба их эрдэнийн намтар магтаал хувь сайтын сүсгийг сэргээгч оршвой” (тө: rnam ’dren rje btsun dam pa rin po che’i// rnam thar bstod tshig skal bzang dad gsos bzhugs// гар бичмэл, 118 хуудас) хэмээх зохиолыг судалгааны үндсэн эх хэрэглэгдэхүүн болгов⁴¹.

Судалгааны арга зүйн хувьд Шар цоржийн бичсэн дан бүтээл буюу нэгж зохиолоос өвөр чанарыг өгүүлэх чимэг, хос төгөлдөр чимгийн шүлгийг түүвэрлэн тодорхойлох аргаар төлөөлөл болгон авч, зохист аялгууны онолтой зэрэгцүүлэн судлахыг хичээсэн болно.

3. Судалгааны хэсэг

“Зохист аялгууны толь” нь нийтдээ 650 орчим бадаг шүлэг бүхий гурван бүлгээс бүрддэг. Нэгдүгээр бүлгийн 105 бадаг шүлэгт ном зохиол туурвих эрдэм, тэр эрдэмд суралцсаны ач тус, сураагүйн гэм алдаа, яруу туурвихын арван эрдэм, зохист аялгууны амь, бие, чимэг гэж юу болох зэрэг яруу найргийн онолын асуудлыг өгүүлсэн байдаг. Мөн зохиолыг шүлэг, үргэлжилсэн, холимог гэж гурван зүйлээр хувааж, тус бүрийн онцлог шинжийг гаргажээ. Бас алив зохиолын зохиомж, хэлбэрийг номлосон байна. Энэ зохиолын зохиомж нь Монголд их нөлөөтэй байв (Дамдинсүрэн, 1987:21).

Дандины “Зохист аялгууны толь” монголын уран зохиолд ямар их нөлөө холбогдолтой байсан нь монгол зохиолчид “Зохист аялгууны толь”-ийг сурч судалж, түүнд утгын ба үгийн тайлбар хийж, жишээ шүлэг зохиож, “Зохист аялгууны толь”-ийн чимгийн зарчмыг ашиглаж, түүх намтар, утга уянгын зохиол бичиж байснаас илэрхий.

སྐྱབས་འཚའ་གསོལ་འདེབས་སྐྱབས་གནས་ངོ་ཤེས་བཞུགས།

³⁸ མ་ནོར་ལྷང་བསྟན་རྗེ་བཙུན་ལྷ་བ་ཚེའི།

མ་འོང་ལྷང་བསྟན་ངོ་མཚར་མཎ་བྱང་བཞུགས།

³⁹ ལྷ་དཀར་བྱ་སྐྱོང་ཉན་ནུ་ཙོ་བྱ་སང།

ལྷ་ལེ་ག་མ་ཉི་སེལ་ཐེ་ཨོ་རྩི་བ།

⁴⁰ Варшавын Их Сургуулийн Дорно дахины судлалын сургуулийн Түрэг судлал, дотоод Ази судлалын тэнхимийн багш, гэвш Рагчаагийн Бямбаа ламтнаас сурвалжлав. 2025.07.20.

⁴¹ Гар бичмэлээр уламжлан ирсэн энэ болон бусад номыг нь Гандантэгчэнлин хийдийн унзад Нацагдорж хадгалж байсныг гэвш Р.Бямбаа ламтан монгол зохиолчдын төвөдөөр бичсэн бүтээлийн эмхэтгэл “Монгол билиг” цувралд гэрэл зургийн эхээр нийтлүүлж, олны хүртээл болгосон билээ (Бямбаа, 2004:395-520).

XVIII-XX зууны эхэн үеийн монголчуудын төвөд хэлээр бичсэн утга зохиолд ийм баримт элбэг бий. Тухайлбал, Халхын Зая бандида Лувсанпринлай, Хөхнуурын Сүмбэ хамба Ишбалжир, Цахар гэвш Лувсанцүлтэм, Алшаа лхаарамба Агвандандар, Их хүрээний Агвантүвдэн равжамба, ханчин хамба Жамьянгарав нар “Зохист аялгууны толь”-д тайлбар бичсэн нь монголын уран зохиолын онолын судалгааны үнэт өв болон уламжилж иржээ.

Дорно дахины утга зохиолын онолын ёсоор зохиол бүтээлийн агуулгыг хамгийн ерөнхийгөөр тахилын хэсэг, бодит хэсэг, төгсгөл хэсэг гэж гурав ангилж үзнэ. Монгол зохиолчдын төвөдөөр бичсэн намтар зохиол нь ихэвчлэн зохиомж хэлбэрийн хувьд энэ онолыг баримтлан, Энэтхэг, Төвөдийн намтар зохиолын зохиомжийг бараг тэр хэвээр нь мөрдсөн байхын зэрэгцээ тахил өгүүлэл, завсрын шүлэг, төгсгөлийн шүлэг зэрэгтээ Дандины “Зохист аялгууны толь”-ийн чимгийн зарчмыг өргөн хэрэглэсэн байдаг. Тодорхой жишээ дурдвал, Цахар гэвш Лувсанцүлтимийн бичсэн “Богд Зонхавын намтар” зохиолын хоёрдугаар бүлгийн тахилын шүлэгт:

“Сайн оюуны айлдахын мандал огоот төгсөөд

Сайн алдрын цагаан гэрэл нь сансрын үзүүр хүртэл түгсэн

Сацлал үгүй мэргэдийн эрхэт шөнийн итгэл

Сайн хувьт амьтны цог болон эдүгээ энд мандлаа” (Лувсанцүлтим, II-1r) гэж буй.

Энэ шүлгийн эхний хоёр мөрд Сайн оюун, Сайн алдар хэмээн богд Зонхавын нэрийг утга далдлан өгүүлээд, сүүлийн хоёр мөрд түүнийг шөнийн итгэл буюу харанхуйг гийгүүлэх гэрэлт саран адил гэгээрэхийг хүсэгч сайн хувьтан олон амьтны замч болов хэмээн шадны эхэнд байх завсардсан хос төгөлдөр чимгийг ашиглан бичжээ.

Цахар гэвш Лувсанцүлтим Монголд бараг 700-аад жилийн түүхтэй “Зохист аялгууны толь”-ийн монгол уламжлалыг хөгжүүлж, түүнд “Утгын чимгийн тийн агуулал оршвой”, “Дууны чимгийн тийн агуулал оршвой” хэмээх хоёр их тайлбар бичсэн их туурвилчийн хувьд яруу илэрхийллийн гол арга болох зохист аялгууны утга, дууны чимгийн олон жишээгээр “Богд Зонхавын намтар”-ыг бичсэн нь тухайн үеийнхээ намтар зохиолын шилдэг жишээ болсон төдийгүй дараа үеийн зохиолч түүхчдийн бүтээлд үлгэр жишээ даган дуурайсан олон бүтээлийг төрүүлэхэд чухал түлхэц болсон зохиол юм.

XX зууны үеийн цорж Дагбажанцан ламын төвөд хэлээр шүлэглэн бичсэн Өндөр гэгээний намтар зохиол бол зохиомж хэлбэрийн хувьд “Зохист аялгууны толь”-ийн онолын зарчмыг баримталсан тахил өгүүлэхүй, бодит хэсэг, төгсгөлийн үг бүхий 13 бүлэгтэй, 3008 мөр, 752 бадаг шүлэг бөгөөд үүний дотор зохист аялгууны утгын болон дууны чимгээр бичсэн олон арван мөр бадаг бий. Төлөөлөл болгон утгын чимгээс өвөр чанарыг өгүүлэх чимгээр бичсэн шүлгийг, дууны чимгээс хос төгөлдөр чимгээр бичсэн шүлгийг жишээ болгон өгүүлье.

Нэг. Өвөр чанарыг өгүүлэх чимгийн шүлгүүд

Зохиол туурвилын утгын дүр дүрслэлийг гаргахдаа үг найруулгын яруу зохисыг бүрэн гүйцэд тохируулан хэрэглэж, утга төгс, уран яруу тансаг болгосон байдлыг зохист аялгууны чимэг (санс: alamkāra, тө: rgyan) гэдэг. Данди үүнийг:

“Зохист аялгууг үзэсгэлэн болгогч аргуудыг

Чимэг хэмээн сайтар өгүүлмүй” (Сумьяа нар, 2017: 65) гэжээ.

བསྟན་མཐོན་ཡངས་དབང་མཛེངས་རྒྱལ་ལོན་ལྷན། །
 མུ་ཤེའི་མུ་རྒྱལ་པོ་མགོན་པོ་རྗེ་དང་། །
 མཁའ་འགོ་རྒྱ་མཚོ་ཡབ་ཡུམ་གཉིས་སྐུ། །
 འབྲུངས་དུས་ལྷན་ཚོགས་རབ་བྱུང་བཅུ་གཅིག་པའི། །
 ཤིང་མོ་ཕག་ལོའི་རྟོར་ལྷ་དགུ་པ་ཡི། །
 མར་ངོའི་ཚོས་བཅུ་མཁའ་འགོ་འདུ་བའི་དུས། །
 ལྷ་བར་ཅན་གྱི་ཉིན་གྱི་ཟླ་ངོ་ལ། །
 འབྲུངས་སྐུ་ལྷན་ཚོགས་སྐུ་ཡངས་དུས་རིང་པོ། །
 ལ་དོག་དཀར་ཞིང་དབྱིབས་ལེགས་ལྷ་ན་སྐུ། །
 འགོ་ལྷན་མེག་གི་དགའ་སྟོན་དུ་གྱུར་པ། །
 རོ་མཚར་ལྷས་བཅས་བསམ་བཞིན་བལྟམས་གྱུར་དོ། ། (Дагбажанцан [a], 4v-5r)

“Хотол төгс мэндэлсэн орон нь арван буян бэлгэ төгс
 Хосгүй ариун, сэтгэлд зохист уул хад, ус мөрөн бүрдсэн
 Халхын нутаг, Хангай хан хэмээхийн
 Хуваарьт багтах "Усан зүйл" гэдэг газар
 Хотол төгс мэндэлсэн язгуур нь Чингис хааны угсаа
 Хослон шашин төрийн ухаан, баатар заль, зориг төгс
 Хаан Түшээт хан Гомбодорж хийгээд
 Ханджамц эцэг эх хоёрын хүү болон
 Хотол төгс мэндэлсний цаг нь арван нэгдүгээр жарны
 Хөхөгчин гахай жилийн Монголын есөн сарын
 Хуучны арван, ханд дагинас хурах цаг
 Хувь ялгамжаат өдрийн үдийн өмнө
 Хотол төгс мэндэлсэн лагшин нь мэлмий уужим уртлаг
 Хосгүй царай цагаан, сайхан дүрст, үзвээс үзэсгэлэнтэй
 Амьтан бүхний харах нүдний баясгалан болсон
 Асар гайхамшигт бэлгэ төгс санасанчлан мэндэлсэн болой”

хэмээн үеийн тоог бүгд ес байхаар зохиомжлон, намтар зохиол бичдэг аргаар, Өндөр гэгээнийг хаана, ямар язгуур угсаанд, хэдийд, ямар дүр төрхтэй мэндэлснийг тодорхой тоочин бичсэн байна. Ингэж дүрийг урлахдаа тухайн зүйл нь оршин байгаа байдлаараа бусдаас ялгарах онцлог, бусдад үгүй зөвхөн түүнд буй өвөрмөц шинж байдал, дүр төрхийг тов тодорхой, ил шууд, утга далдлалгүй, хэтрүүлж болон дутаалгүй, магтаж дөвийлгөлгүй, муушааж доройтуулалгүй тоочин өгүүлэх нь зохист аялгууны утгын чимгийн анхны өвөр чанарыг өгүүлэх чимэг (тө:rang bzhin brjod) юм.

Өвөр чанар гэдэг нь төвөд хэлнээс монгол хэлэнд орсон “араншин” хэмээх үгийн монгол орчуулга бөгөөд өөрийн төрөлх ахуй зан байдал, төрөлх чанар, уугуул зан, өөрийн шинж байдал гэх утгыг илэрхийлнэ. Жишээ нь, галын араншин буюу өвөр чанар нь халуун бөгөөд түлдэг, усны өвөр чанар нь шингэн бөгөөд норгодог, нарны өвөр чанар нь гэрэлтүүлж гийгүүлэн, дулаацуулдаг, сарны өвөр чанар нь гэрэлтүүлж гийгүүлэн, сэрүүцүүлдэг мөн чанартай (Сумьяа нар, 2017: 67).

Өвөр чанарыг өгүүлэх чанар нь дотроо *язгуурын өвөр чанарыг өгүүлэх* (тө: rigs kyi rang bzhin brjod pa), *үйлсийн өвөр чанарыг өгүүлэх* (тө: bya ba rang bzhin brjod pa),

སྤྱི་ལོ་མཚན་ན་མཚན་ནས་མ་སྒོས་ཀྱང་། །
ཨ་ཏི་ག་དང་རྗེ་བཙུན་ཚོང་ཁ་པའི། །
སྤྱི་ལོ་ལྟ་བུ་རྗེ་དེའི་སྤྱི་ལོ་བར། །
ངོ་ཤེས་བ་རྒྱ་ཡོད་བཞིན་བ་འདི་ཡང་། །
རྗེ་འདིའི་ཐུན་མོང་མིན་པའི་བྱང་ཚེས་ལགས། ། (Дагбажанцан [a], 103r-103v)

“Ханьцашгүй лагшин нь шулуун, үзэмж тунсаг
Хамаг мутар, хуруу нь бөөрөнхий, дэлгэр
Өлмий шагай нарийн, тэргүүн шүхэр мэт дугариг
Өндөр магнай тэнүүн, харахуй мөшөөл тогтонгуй
Хөмсөг жирвэгэр, нигуур зохицолтой, хамар өндөр
Хэлбэр сайн сонорын хормой урт үзэсгэлэнтэй
Ерөнхий дүр төрх сүр жавхлантай
Ерөөс дахин харахыг эрхгүй хүсэх
Үнэн сүжгийн хүчээр татагдан үзвээс
Үзэх нүд хараа салгамгүй, нэн ялангуяа
Хоёр хацрын тушаа хос завжны хажууд
Хар өнгөт урт зөөлөн живэр сахалыг
Татваас тохой хэмжээ хүрэх
Талбиваас нар зөв эрчлэх
Бурхны оройн үснэр мэт
Бусдаас маш гайхамшигтай бөгөөд
Аврал богд дээдсийн лагшин дүрийг
Аливаа хэн бээр үзвээс алдрыг эс дурдавч
Адиша гэгээн, богд Зонхавын лагшинтай
Адил буй за Богдын лагшин хэмээх
Бодитой танин мэдэхийн шалтгаан бүрдсэн нь
Богдын нийт бус онцгой ялгал мөн болой” хэмээн язгуурын өвөр чанарыг өгүүлэх
чимгээр Өндөр гэгээний лагшин цогцын харагдах байдлыг хүмүүн төрөлтний нийтлэг
шинж байдлаар өлмийгөөс тэргүүн хүртэл тоочин өгүүлсэн нь хүний язгуурын түгээмэл
шинж болох бөгөөд Өндөр гэгээний зөвхөн түүнд заяасан өвөрмөц шинжээр дүрслэн
өгүүлсэн нь бусад хүнээс ялгагдах шинж болж байна. Ялангуяа гэгээнтний хоёр завжны
орчим хар живэр сахлын хэмжээ, эрчлээ, үзэмжийг нарийн тодорхой өгүүлсэн бөгөөд
энэ нь Өндөр гэгээний язгуурын өвөр чанар юм.

Дараагийн бадагт:
གསུང་ནི་ཁྲོལ་ལ་སྤྲོན་བ་ཆེ་ལ་དང་། །
སྤྱི་ལོ་སྤྲོད་གསུང་ཚེས་མཐུན་གསུང་འབྲོན་པ། །
དང་བ་ཡེ་མེད་བ་དག་ཐོས་ནས་ཀྱང་། །
དང་བ་སྒོ་བུར་སྤྱོད་ཆུང་དུ་འགྲོ། ། (Дагбажанцан [a], 103v)

“Эрхэм зарлиг нь ихэд яруу, шударгуу, сонсголонтой
Элдэв үгсийг айлдахуй номын зарлиг дуурсгах
Огтын сүсэг үгүй хэн хүмүүн сонсовч

Огоот сүсэг төрж, сэтгэлийг номхотгон чадах” гэж Өндөр гэгээний айлдал зарлигийн чихний мэдрэхүйд сонсогдох байдал, түүгээр дамжин сэтгэлд буюу зургаа дахь мэдрэхүйд үүсэх үйлдэл, чадлыг огтын сүсэггүй хүн ч гэсэн сонсох юм бол итгэл сүсэг төрж, бодол сэтгэл нь өөрчлөгдөнө гэж тов тодорхой, ухаж ойлгоход хялбараар илэрхийлжээ. Дүрс, дуу, үнэр, амт, хүрэлцэхүй эдгээр нь дорно дахины хүслийн таван эрдэм хэмээх нэрийтгэлд хамаарах ойлголт болно. Үүнд нүдний мэдрэхүй нь өнгө, хэлбэр, чихний мэдрэхүй нь дуу авиа, хэлний мэдрэхүй нь амт, хамрын мэдрэхүй нь үнэр, биеийн мэдрэхүй нь хүрэлцэхүй бөгөөд эдгээрийн чинадад сэтгэл хэмээх зургаа дахь мэдрэхүй байна гэж үздэг буддын ойлголтоор үүнийг тайлбарлаж болох юм.

Өвөр чанарыг өгүүлэх чимгийн хоёр дахь нь *үйлсийн өвөр чанарыг өгүүлэх чимэг* болно. Энэ нь “үйлийн эзэн бээр үйлийн орон байц алин нэгнээ үйл алиныг үйлдсээр байгаа буюу үйлдэж дууссан шинж байдлыг шулуун шударгаар дурдан өгүүлэхийг” (Сумъяа нар, 2017: 69) хэлэх бөгөөд үүний үр дүнд үйлдэгч эзний зүгээс үйлийн оронд үзүүлэх шууд үйлдлийг заадаг. Энэ чимгээр Төвөдийн Бодхайвын бичсэн жишээ:

ཡི་ཤེས་ཚེན་པོས་སྤྲོད་ཞི་མཉམ་བར་གཟིགས།

བརྩེ་བས་གདུལ་བྱ་འདུལ་ལ་སློ་བས་བྲངས།

གཞོན་མེད་གསུང་གིས་རྣམ་གྲོལ་ལམ་སྟོན་བ།

གདུལ་དགའི་ཞིང་འདི་ཡོངས་བཟུང་ཤ་གྲིའི་དྲོག། (Бодхайва, 2000: 446)

“Арилсан их билгүүнээр сансар нирвааныг машид тольдож

Асрал энэрлээр шавийг номхотгохын дуршлаар удирдагдан

Аяс шулуун зарлигаар сайтар гэтлэхийн мөрийг үзүүлж

Аяа, номхотгохуйяа бэрх энэ орныг огоот эзэлсэн Шагжагийн манлай” (Бодхайва, 2000:446) хэмээн Ялж төгс нөгчсөн Бурхан багшийг илт мэдэх билгүүнээр хамаг бүгдийг тэгшид тольдон болгоож, их асрал энэрлээр хувь төгс шавь нарыг боловсруулан удирдсан, үнэн сайн зарлигаар зовлонгоос гэтлэх зам мөрийг зааж, цөвийн цагийн номхотгохуйяа бэрх орныг даган барьсан гэж шууд шулуунаар өгүүлжээ.

Шар цорж Дагбажанцан үйлсийн өвөр чанарыг өгүүлэх чимгээр:

ཐུགས་ནི་ཤིན་ཏུ་སྐྱམ་ཞིང་དགྲིལ་ཆེ་ལ།

ཐུགས་རྒྱད་འཇམ་བཤམ་ཏུ་རྣམས་སྤྲོད་ལས།

ཉ་ཅང་མངོན་གསལ་ཆེ་རང་མ་མཛད་བས།

འཇིགས་ཉེན་ཐབས་རྩལ་ལ་རྫོངས་བཤམས་ལ།

ཐབས་མཁས་ཉེན་འབྲེལ་བྱད་བར་དུ་མ་དང་།

སྟོག་གྱུར་གཟིགས་པའི་མངོན་བར་ཤེས་བཤིས།

སྤང་དོར་བྱད་བར་ལུང་སྟོན་མཛད་བཤིགས།

རྫོངས་འདིའི་སྐྱེ་གྲིའི་ངལ་བསོའི་སྟེགས་གཅིག་གྱུར། | (Дагбажанцан [a], 103v-104r)

“Аугаа таалал нь маш уужим эн их

Ашид тааллын дотоод эрдмийг далдалж

Асар илт тодорхой үл үзүүлэн зохиовч

Аюул занал, арга ёсонд мунхарсан бүхэнд

Уран мэргэн арга, шүтэн барилдлага, ялгамжаа их

Улмаар эчнээ далдыг болгоохын илт мэдлээр

Авах, огоорох ялгал, эш бошиг үзүүлэн зохиосон нь

Ахуй энэ орны хүмүүний алжаалыг сэргээх түшиг аж” хэмээн Өндөр гэгээнтэн хэчнээн өөрийн эрдмийг нуух ёсыг үргэлж үзүүлж явдаг боловч арга ядарсан, аюул зовлонд учирсан олон түмэнд ил далдыг болгоох илт мэдэл, билиг ухаанаараа мэргэн арга зохион хүн арддаа түшиг тулгуур болж, тэтгэн тусалж байдгийг үйлсийн өвөр чанарын чимгээр магтан өгүүлсний зэрэгцээ:

ཡོན་ཏན་དབེན་ས་སྐྱ་བརྒྱ་ཀྱི་དགོངས་བཟུང། |

ལྷ་མའི་རྣལ་འབྱོར་ཉམས་བཞེས་གཙོ་མཛད་དེ། |

ཐུན་མོང་ཡིན་མིན་རྟོགས་པ་མངོན་གྱུར་ཏེ། |

གྲུབ་པའི་གོ་འཕང་མཐོན་པར་གཤེགས་པར་མཛད། | (Дагбажанцан [a], 104r)

“Эрдэм нь Бэнса чихний дамжлага тааллын шим

Эгнэгт багшийн егүзэр бясалгалыг эрхэмлэн зохиож

Эл нийтийн хийгээд нийтийн бус онол илт болж

Эгнэшгүй бүтээлийн хутгийн өндөрт залран зохиов” хэмээн давхар эрдмийн өвөр чанарыг өгүүлэх чимгээр хамтатган гаргасан байна.

Эрдмийн өвөр чанарыг өгүүлэх чимэг гэдэг нь өвөр чанарыг өгүүлсэн чимгийн ахуй ёсыг гаргасны дээр өгүүлэгдэх орон болсон тухайн бодгалын эрдэм чадлын өвөрмөц төрх, түүний нөлөөллийг тодруулж өгүүлдэг чимэг бөгөөд энд өгүүлж байгаа эрдэм нь гэм ба эрдэм гэдгийн эрдмийг заасан утга бус, аливаа юмсын өөрийнх нь бусдаас ялгарах ахуй шинжийг тодруулж гаргахыг хэлж буй юм (Сумьяа нар, 2017: 70).

Шар цорж мөн Өндөр гэгээний урьж санасан үйлс, үүтгэл зохионгуй нь үеэс үед дэлгэрч, ард олонд ач тусаа өгсөөр буйг:

འཕྲིན་ལས་ནམ་མའི་ཇི་མེད་གནས་ཀྱི་བར། |

རྒྱན་མི་འཆད་དང་རྒྱན་གྲུབ་མཛད་འཕྲིན་གྱིས། |

བདག་ཅག་ལ་སོགས་མཐའ་མེད་འགྲོ་བ་རྣམས། |

རང་རང་སྐལ་བ་ཇི་བཞིན་འདྲེན་པར་མཛད། | (Дагбажанцан [a], 104r)

“Үйлс нь огторгуй хэзээд орших хүртэл

Үл тасалдах, аяндаа бүтэх зохионгуй үйлсээр

Үтэл би тэргүүтэн хязгааргүй олон амьтныг

Өөр өөрийн хувь ямар мэтчилэн удирдан зохиов” хэмээн өвөр чанарыг өгүүлэх чимгээр үйлийн эзний эрдэм чадлыг тодруулан бичжээ.

Төвөд хэлээр бичсэн шүлэг зохиолд өвөр чанарыг өгүүлэх чимгээр дүрийг шударга шулуунаар тоочин гаргахаас гадна шүлгийн үеийн тоог тэнцүүлэх зорилгоор илт өгүүлэх нэр буюу ёгт нэрийг ашиглах тохиолдол элбэг. Илт өгүүлэх нэр гэдэг нь нэг юмыг шууд нэрлэлгүй, түүний онцлог шинж, өвөрмөц төрхөөр төлөөлүүлэн нэрлэх арга бөгөөд илт өгүүлэх нэр нь шүлэглэсэн зохиолыг уран тансаг найруулгаар чимж, шүлгийн хэмжээ хэмнэл тааруулах үүрэгтэй байдаг (Бүрнээ, Энхтөр, 2003: 103). Энэ нь зохист аялгууны утгын чимгийн адилтгалын чимэгтэй ойролцоо ойлголт юм.

Шар цорж нэг талаас зохиолынхоо хэл найруулгыг уран яруу болгох, нөгөө талаас шүлгийн үеийн тоог тэнцүүлэх зорилгоор илт өгүүлэх нэрийг хэрэглэж:

ལེགས་བྱས་ཁྱུང་ཚོན་སྐྱེས་ཀྱིས་ཉེར་དངས་ཏེ། |

ལེགས་བཤད་འོད་བརྒྱའི་རྣང་བས་ཐུབ་བསྟན་སྒྲིང། |

ལེགས་པར་གསལ་མཛད་ཚོ་བཟང་ཉིན་ལྗང་དབང་། །

ལེགས་ཚོགས་ཀྱི་འབྲུང་བླ་མར་སྐྱོང་ནས་འདུད། །

རྣམ་འདྲེན་སྐྱབས་མགོན་དམ་པའི་སྨྱོད་ཚུལ་འགའ། །

རྣམ་ཐར་རྒྱ་མཚོ་ཆེན་པོ་ལས་བཏུས་ནས། །

རྣམ་འདྲེན་བླ་མར་མོས་པའི་དད་གསོས་སྟེ། །

རྣམ་ཐར་རྒྱ་ཐུགས་ཆ་ཚམ་བརྗོད་ལ་སྟོ། ། (Дагбажанцан [b], 2r-2v)

“Сайн үйл хөх гардиас төрсөн дөтөд татсан

Сайн номлол зуун гэрлийн үзэгдлээр бурхны шашны тивийг

Сайтар тодруулан зохиогч сайн оюун өдөр үйлдэгчийн эрхт

Сайн чуулган бүхэн гарагч багшид зүрхнээс сөгдмүй.

Тийн удирдагч аврал итгэл дээдсийн зарим явдал ёсыг

Тийн намтар цадигийн их далайгаас хураангуйлж

Тийн удирдагч багшид сүсэглэх сүсгийн сэлбэлгэд

Тийн цадиг усны дуслын хувь төдийхөн өгүүлэхийг дурламуй” хэмээн бичжээ.

Энэ шүлэгт үүр гэгээрэхийг “хөх гардиас төрсөн”, нарыг “өдөр үйлдэгчийн эрхт”, нарны цацраг туяаг “зуун гэрэл” хэмээн илт өгүүлэх нэрээр өгүүлээд, дараагийн дөрвөн мөрд намтрыг бичих болсон шалтгаанаа “Зохист аялгууны толь”-ийн гуравдугаар бүлэгт өгүүлэх дууны чимгийн эхэнд буй “хос төгөлдөр чимэг”-ээр бичсэн байна.

Хоёр. Хос төгөлдөр чимгийн шүлгүүд

“Зохист аялгууны толь”-ийн гуравдугаар бүлэгт 187 бадаг шүлгээр, зохиолыг найруулан туурвихын гол хэрэглүүр болсон дууны чимгийн эрдэм болоод зохист аялгууг зохисгүй болгодог найруулгын арван гэмийн тухай өгүүлжээ.

Дууны чимэгт утгыг гаргаж ирэгч үгсийн найрлагад голлон төвлөрч, хэлэх гэсэн санаагаа яруу тансаг, зөв оновчтой найруулахад юуг анхаарвал зохистойг “хос төгөлдөр” (тө: zung ldan rgyan), “үйлдэхүйеэ бэрхийн бусад ялгал” (тө: bya dka' ba'i khyad par), “эгшиг тэргүүтнийг магадлах үйлдэхүйеэ бэрх” (тө: dbyangs sogs nges pa'i bya dka') гэсэн гурван зүйлээр өгүүлнэ (Бодхайва, 2022: 141).

Төвөд, Монголын эрдэмтэн зохиолчид дууны чимгийн доторх хос төгөлдөр чимгээр зохиол бүтээлээ туурвисан нь түгээмэл. Хос төгөлдөр чимэг (тө: zung ldan rgyan) гэдэг нь нэгэн бадаг шүлгийн дотор буй утгын хувьд ялгаатай, дуудлага ойролцоо үе буюу үгсийг нэг дор нь, эсвээс өөр өөр газарт дахин давтаж найруулж, зохиолыг уран тансаг болгох арга юм. Хос төгөлдөр чимгийг ерөнхийд нь завсардсан болон эс завсардсан чанарт хос төгөлдөр чимэг гэж ангилж болох ба нэгэн бадаг шүлгийн эхэнд, дунд, адагт хаана нь ч тохиолдож болдог. Хаана орсноос нь шалтгаалаад өөр өөрөөр нэрлэх бөгөөд дотроо олон зүйл болж задарна. Бодхайва үүнийг тайлбарлахдаа:

བར་མ་ཚོད་དང་བར་ཚོད་བདག ། །

ཡི་གེ་ཚོགས་བ་བསྐོར་བ་ནི། །

དེ་ཟུང་ཐུན་ཡང་རྐང་བ་ཡི། །

དང་པོ་བར་མཐའ་སྨྱོད་ཡུལ་ཅན། (Бодхайва, 2022: 141)

“Эс завсардсан хийгээд завсардсан чанарт

Элдэв олон үгсийг хүрээлүүлсэн

Тэрхүү хос төгөлдөр нь ч хөлийн

Тэргүүн, завсар, эцсийн явдал оронт болой” хэмээн эс завсардсан болон завсардсан хос төгөлдөр чимэг нь шүлгийн нэгэн мөрийн эхэнд, дунд, адагт, ер хаана нь ч тохиолдуулж болох тухай өгүүлжээ. Мөн:

གཅིག་གཉིས་གསུམ་བཞི་ཤང་བ་ཡི། |

ཟུང་ཟུན་ནམས་ཀྱི་ནམ་ཉིག་ནི། |

ཐོག་མ་བར་མཐའ་བར་དང་མཐའ། |

བར་དང་ཐོག་མ་ཐོག་མཐའ་ཀུན། (Бодхайва, 2022: 143)

“Нэг, хоёр, гурав, дөрвөн хөлийн

Нийт хос төгөлдөр бүхний шинжлэл гэвэл

Тэргүүн, дунд, эцэс болон

Дунд эцэс, дунд эхэн, эхэн адагт” гэж нэгэн шүлгийн дотор заавал нэг мөрд гэлгүй мөр хооронд ч давтан хэрэглэж болох тухай өгүүлсэн бол:

ཡང་དག་དབྱེ་བ་ལས་སྐྱེས་པ། |

དེ་ནམས་དབྱེ་བ་ཤིན་ཏུ་མང། | (Бодхайва, 2022: 143)

“Үнэхээр ялгаснаас салсан

Тэдгээрийн ялгал маш олон буюу” гэж хос төгөлдөр чимэг нь дотроо олон зүйл ялгалтай болохыг заажээ.

Завсардсан хос төгөлдөр чимгээр бичнэ гэдэг нь чимэг болж буй үгийг шүлгийн эхэн, дунд, адаг аль нэгэн газарт тасалдалтайгаар буюу өөр өөр газар давтан хэрэглэх арга бөгөөд давтан хэрэглэх үг болон үеийн дунд өөр үг, үе орох эсвээс хоёр хөлд давтан хэрэглэвэл завсардсан чанарт болно. Үүнээс *мөрийн эхэнд завсардан орсон хос төгөлдөр чимгийг* Данди 13 зүйлээр (Бодхайва, 2022: 264-267) өгүүлжээ. Шар цоржийн бичсэн намтар зохиолд энэ аргаар бичсэн цөөнгүй мөр бадаг бий. Тухайлбал, намтар зохиолын тахил өгүүлэлд:

རྟ་འབྲུམས་རྒྱལ་བའི་ཡབ་གཅིག་འཇམ་པའི་དབྱངས། |

རྟ་ཚོངས་མཐའ་འཁོབ་བདག་ཅག་འདྲེན་པའི་ཕྱིར། |

རྟ་མཛོས་དུར་སྐྱིག་གར་རོལ་སློབ་བཟང་བསྟན། |

རྟ་གསལ་ཇེ་བཙུན་དམ་པར་གསོལ་བ་འདེབས། | (Дагбажанцан [a], 3v-4r)

“Машид хэтийдсэн ялгуусны гагц эцэг Зөөлөн эгшигт

Машид алс бөглүү, мунхаг биднийг удирдахын тухайд

Машид үзэсгэлэнт эл шарын бүжиглэлээр Сайн оюутын шашныг

Машид тодруулагч Жэвзүндамба хутагтад залбирал талбимуй” хэмээх

Жэвзүндамба хутагтын бүх дүрд зориулсан залбирал болоод

རྒྱུ་ས་གསུམ་ཀུན་འདུས་ཇེ་བཙུན་རྒྱལ་བའི་སྐ། |

རྒྱུ་ས་མགོན་སློབ་བཟང་བསྟན་པའི་རྒྱལ་མཚན་ལ། |

རྒྱུ་ས་འཚོལ་བདག་གིས་སྤོང་ནས་གསོལ་བ་འདེབས། |

རྒྱུ་ས་མཚོག་ཁྱོད་ཀྱིས་ཐུགས་རྗེས་རྒྱབས་ཏུ་གསོལ། | (Дагбажанцан [a], 5v-6r)

“Аврал гурав бүхэн хурсан Богдын хувилгаан

Аврал итгэл Лувсандамбийжанцанд

Авралыг эрэгч би бээр зүрхнээс залбирал талбимуй

4. Талархал

Тус өгүүллийг Шинжлэх ухааны академийн грант “Монгол зохиолчдын төвөдөөр бичсэн зохиол-3” төслийн хүрээнд бичив. Төслийг санхүүжүүлсэн Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газар, эх хэрэглэгдэхүүнээр хангасан гэвш Р.Бямбаа ламтан, судалгааны арга зүйн талаас үнэ цэнтэй зөвлөгөө өгсөн Төвөд судлал сэтгүүлийн редакцын зөвлөлийн гишүүдэд талархлаа илэрхийлье.

5. Дүгнэлт

Монгол намтар зохиол агуулгын хувьд дорно дахины олон улс орны бичиг соёлын хүрээнд өргөн баримталдаг яруу найргийн уламжлалт онол болох Дандины “Зохист аялгууны толь”-ийн онолын зарчмыг баримтлан эхлээд мөргөл, дараа нь тухайн зохиолын бодит гол хэсэг, эцэст нь өлзий ерөөлийн үгтэй байх бөгөөд гол хэсэгтээ Дандины “Зохист аялгууны толь” доторх утгын гучин таван чимгийн анхан “өвөр чанарыг өгүүлэх” чимгийн аргаар тухайн хүний язгуур, үйлс, эрдэм, эд гэсэн дөрвөн шинж байдлыг сайшаан магтахгүй, муушааж гутаахгүй, шударга үнэнээр өгүүлдэг нийтлэг онцлогтой ба уншигчдын сонирхлыг татах үүднээс зохиолыг уртай, уянгатай, утга төгс болгодог уран сайхны олон арга, дуу, утгын чимгийг өргөн хэрэглэнэ.

Хорьдугаар зууны үеийн монгол зохиолч Говь мэргэн вангийн хошууны Баян-Овоогийн “Шар цорж” хэмээн олноо алдаршсан Дагбажанцан (1855-1927) ламын төвөд хэлээр туурвисан “Машид удирдагч Жэвзүндамба их эрдэнийн магад намтар магтаал хувь сайтын сүсгийг сэргээгч” хэмээх Өндөр гэгээний намтар зохиол бол зохиомж хэлбэрийн хувьд Дандины “Зохист аялгууны толь”-ийн онолын дагуу тахил өгүүлэхүй, бодит хэсэг, төгсгөлийн үг бүхий 13 бүлэгтэй бичсэн, 3008 мөр, 752 бадаг шүлэглэсэн зохиол юм.

Шар цорж Дагбажанцан Өндөр гэгээний намтар зохиолын бүлэг бүрд уран зохиолыг яруу тансаг болгогч зохист аялгууны дуу, утгын “хос төгөлдөр”, “өвөр чанарыг өгүүлэх” чимгийн аргыг хэрэглэн, “Зохист аялгууны толь”-ийн онолын уламжлалыг хөгжүүлсний зэрэгцээ Төвөд, Монголын яруу найргийн онолын сэтгэлгээ, түүхэн туршлагад бүтээлч шинэчлэл хийж, яруу найргийн тэрхүү хэвшин тогтсон загварыг монгол шүлгийн хос холбоц, эн зэрэгцүүлэх, авиа ижилсүүлэх арга хэрэглүүрээр баяжуулан, урнаар сэтгэх, найруулах олон боломжийг ашиглан бичсэн нь XX зууны монгол зохиолчийн төвөдөөр шүлэглэн бичсэн намтар зохиолын төлөөлөх шинжтэй зохиол болжээ.

Ном зүй:

А. Эх сурвалж:

[Бодхайва] (2000; 2022) bod mkhas pa mi pham dge legs nam rgyal. snyan ngag gi stan bcos chen po me long la 'jug pa'i bshad sbyar dañdi'i dgongs rgyan zhes bya ba bzhugs so. Dharmasala. Tibetan cultural printing press. 2020; ser byes rig mdzod chen mo'i rtsom sgrig khang / 2022.

[Дагбажанцан] nam 'dren rje btsun dam pa rin po che'i// nam thar bstod tshig skal bzang dad gsos bzhugs// //Бямбаа Р. (2004) The Collected Biographies of Jebzundampa

Khutukhts of Khalkha, MONGOL BILIG Gsung 'bum Series, Vol. I. Compiled by Byambaa, R. Ulaanbaatar.

[Жамьянгарав]. snyan ngag rtsa 'grel gyi sbyi'i don rnam par bzhag pa tshangs pa'i sgra dbyangs bzhes bya ba bzhugs so// модон барын судар.

В.Судалгааны бүтээл

Бүрнээ, Д (2022) *Лувсанишивагийн сүмбүмийн гарчиг болон төгсгөлийн үгийн тухай*, Төвд судлал. Том XI, Fasc.3, УБ., х.27-43 [Burnee, D., Luvsanshivagiin sүmbүmiin garchig bolon tögsgöliin үgiin tukhai [A Study of the Title and Colophon of Luvsanshiva's Sumbum.], Ulaanbaatar, 2022]

Бямбаа, Р (2004) *Монголчуудын төвөд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл. 1 боть*, *The collected Biographies of Jebzundampa khutukhts of Khalkha, MONGOL BILIG gsung 'bum series, Vol.I*, УБ., [Byambaa, R., Mongolchuudyn tövöd kheleer tuurvisan mongol khelend orchuulsan nom zүйin бүrtgel. 1 boti [The collected Biographies of Jebzundampa khutukhts of Khalkha, MONGOL BILIG gsung 'bum series, Vol.I], Ulaanbaatar, 2004]

Гомбожав, С (1959) *mongyolцud-un töbed kele-ber jökiyaysan jökiyal-un jүйil*. //Studia mongolica. T.I, Fasc. 28., УБ., [Gombojav, S., Mongolchuudyn tövöd kheleer zokhioson zokhiolyn zүйil [Works Written in Tibetan by Mongolian Authors.], Ulaanbaatar, 1959]

Жамьянгарав, С. (2011) *Цаглахуй санааны найлзуур мод*. Жишээ шүлгийг төвд хэлнээс орчуулж, эрдэм судлалын боловсруулалт хийсэн Л.Хүрэлбаатар., УБ., [Jamyangarav, S., Tsaglakhui sanaanii nailzuur mod [Tree of superior intention. An Example Poem Translated from Tibetan with Academic Commentary and Analysis by L.Khurelbaatar], Ulaanbaatar, 2011]

Лувсанцүлтим, (2004) *Богд Зонхавын намтар*. Монгол бичгээс хөрвүүлж, эрдэм шинжилгээний удиртгал тайлбар сэлт үйлдсэн Д.Наранцэцэг, редактор Д.Цэрэнсодном. УБ., [Luvsantsulthim, Bogd Zonkhavyn namtar [Biography of Je Tsongkhapa, Transliterated from the traditional Mongolian script, with scholarly introduction and annotations by D. Narantsetseg; edited by D.Tserensodnom], Ulaanbaatar, 2004]

Лауфер, Б. (1927) *Очерк монгольской литературы*. Очерк монгольской литературы, перевод В.А.Казакевича, под редактор Б.Я.Владимирцова. Ленинград., [Laufer, B., xxxxxx [xxxxx], Ulaanbaatar, 2011]

Мягмарсүрэн, Г. (2024) *'bum rams pa'i rtsom bsgrigs//*, УБ., [Myagmarsuren, G., 'bum rams pa'i rtsom bsgrigs// [work of 'bum ram pa], Ulaanbaatar, Ganzam printing, 2004]

Ринчен, Б. (1970) *Монгол шүлгийн учир*, Хэл зохиол судлал. Том. VIII, Facs. II, УБ., х. 21-32 [Rinchen, B., Mongol shүlgiin uchir [On the Meaning of Mongolian Poetry.], Ulaanbaatar, 2022]

Сумъяа, Д., Няммягмар, Б., Ням-Очир, П., Ерөөлт, Ж., Лхагважав, Б., (1970) Дандины “Зохист аялгууны толь”-ийн гол нэр, утгын тайлбар, УБ, Соёмбо принтинг [Sumiya, D., Nyammyagmar, B., Nyam-Ochir, P., Yuruult, J., Lhagvajav, B., Dandiny “Zohist ayulguuny toli”-iin gol ner, utgyn tailbar [The Main Terms and Semantic Interpretation of Dandin’s *Mirror of Poetry*], Ulaanbaatar, Soyombo printing, 2022]

Позднеев А. (1880) *Обрацы народной литературы монгольских племен, вып. I*, Спб

Хүрэлбаатар, Л. (1999) *Эсэруагийн эгшиг дуун*, УБ., [Khurelbaatar, L., Eseruagiin egshig duun, [Melodious of Eserua], Ulaanbaatar, Interpress printing, 1999]

Цэрэнсодном, Д. (1977) *Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал*, УБ., [Tserensodnom, D., Mongol shülgiin onol tүүhiin zarim asuudal [Some Issues in the Theory and History of Mongolian Poetry], Ulaanbaatar, 1977]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>